

7

ДЭЛХИЙН ХӨГЖИЛ БА ИРЭЭДҮЙН ЗАХ ЗЭЭЛ, БИЗНЕСИЙН БОЛОМЖ

Л.Нямцэрэн

1. Дэлхийн хөгжлийн ирээдүйн дүр зураг

Өнөөгийн бидний амьдарч буй үеийг эрдэмтэд дэлхийн хөгжлийн их шилжилтийн эрин буюу тогтвортой хөгжлийн гол хандлага болох гариг ертөнцийн эриний эхэн үед хамааруулан авч үзэж байна.

1980-аад оноос өнөөг хүртэлх хугацаанд дэлхийн хэмжээнд дараахь гол өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- **Дэлхийн хүрээлэн буй орчин.** Хүмүүс дэлхийн цаг уурын өөрчлөлт, озоны цоорхой, биологийн төрөл зүйлийн сүйрлийг ойлгож, даян дэлхийн дээд хэмжээний уулзалтууд зохион байгуулав.
- **Технологи.** Орчин үеийн эхэнд компьютер, эцэст нь интернет, мэдээлэл холбооны тоон технологи бий болов.
- **Геополитик.** ЗХУ задарч, хүйтэн дайн төгсч, дэлхийн капиталист системийн ноёрхлын гол саад арилав.
- **Эдийн засгийн интеграцлал.** Бараа, санхүү, хөдөлмөр, хэрэглэгчдийн бүх зах зээл улам илүү даяаршив.
- **Байгууллага.** Дэлхийн худалдааны байгууллага, үндэстэн дамнасан корпорацууд, олон улсын хэмжээнд холбогдсон иргэний нийгэмлэг зэрэг дэлхийн шинэ байгууллагууд бий болж, дэлхийн хэмжээний алан хядах үйл ажиллагаа газар авч байна.

Дээрхи бүх өөрчлөлтүүд нь өнөөдөр соёл иргэншлийн гариг ертөнцийн эринд орсныг нотолж байна. Өнөөгийн эрс өөрчлөлтөөс ирээдүйн дэлхий ямар болох вэ? Энэ асуултад хариу болгон Стокхолмын байгаль орчны институтын глобал дүр зургийн бүлэг

Уламжлалт ертөнц, Эмх замбраагүй ертөнц, Их шилжилт гэсэн гурван хувилбар дүр зургийг тодорхойлсны зэрэгцээ дэлхийн хөгжлийн дараахь таамаглалыг дэвшүүлсэн байна.

1990-2015 он: Зах зээлийн хөөрөл, түр зогсолт, дахин сэргэлт:

1990-ээд онд мэдээлэл холбооны технологиос сүлжээний эдийн засгийн анхны давалгаа үүссэн нь эдийн засгийн өсөлтийн гол түлхэц болж, тоон технологи хүмүүсмин хэрэглээний гол зүйл болов. Гэвч материаллаг хэрэглээний илүүдэл хүмүүсийн амьдралын хангалттай суурь болж чадахгүй болж, даяаршил туйлшралыг зөөлрүүлэх бус харин хүмүүсийн уур хэлэн, эсэргүүцлийн шинэ хэлбэрүүдийг бий болгож, зах зээлийн нууц гар хүчтэй боловч хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангаж чадахгүй нь тодорхой болсноос 1990-ээд оны эцсээр байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн шудрага байдлын төлөө олон улсын эдийн засгийн байгууллагууд, даяаршлын эсрэг олон нийтийн сул хөдөлгөөн өрнөж эхлэсэн боловч шинэ зууны эхнээс терроризмын эсрэг АНУ-аар толгойлуулсан эвсэлд дэлхийн ихэнх орнууд нэгдэн тодорхой амжилт гаргасан явдал, худалдааны чөлөөлөлт, шинэчлэл, зах зээлийн өргөжил зэрэг нь даяаршлын шинэ давалгааг бий болголоо. Шилэн кабелийн болон утасгүй холбооны сүлжээ улам өргөжин, үндэстэн дамнасан корпорацууд хүчээ авч үндэсний засгийн газруудад хүчтэй нөлөөлж, эд баялагийн үйлдвэрлэл өмнө байгаагүйгээр өссөөр байна.

2015 он: Хямрал: Өмнөх арваад жилд бий болсон хурцадмал байдал, зөрчлийн зайлшгүй үр дагавар нь 2015 оны үед хямрал болох магадлалыг бий болгож байна. Гэвч амьдрал цаашид үргэлжилж, өнгөрсөн үетэй харьцуулахад дэлхийд гэнэтийн сонин өөрчлөлт болно. Эдийн засгийн өсөлт бүхий өмнөх үе зөрчлийг ихэсгэх боловч ихэнх орнуудад орчин үеийн байгууллагуудыг бий болгон терроризмыг тодорхой түвшинд барьж чадах зэрэг амжилт гарна. Гэхдээ хүрээлэн буй орчны доройтол, эдийн засгийн болон нийгмийн туйлшрал, эдийн засгийн зөрчлийн мөргөлдөөний гүн хямралыг урьдчилан харж түүнээс урьдчилан сэргийлж чадахгүй хүрнэ. Нөөцийн хомсдол, экологийн доройтолтой холбогдсон зардлын өсөлт хүмүүс, экосистем, дэлхийн эдийн засагт эргэн нөлөөлнө.

2015-2025: Дэлхийн хэмжээний өөрчлөн байгуулалт: Засгийн газрууд иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, том корпорацуудад нөлөөлөх, хүрээлэн буй орчноо цэвэрлэх, эрх тэгш шудрага байдлыг бий болгох, ядуурлыг бууруулах ихээхэн чармайлт тавих шаардлага гарна. Тэр нь олон улсын түвшинд нөлөөлж, Дэлхийн шүүх, сэргээн байгуулсан Дэлхийн Холбоо /өмнөх НҮБ/ Дэлхийн Зохицуулах

байгууллага /өмнөх ОУВС, Дэлхийн банк/ бий болно. Өмнөх зууны сүүлчээр их яригдан дараа нь бараг мартагдах шахсан тогтвортой хөгжлийн асуудал дахин сэргэнэ. Гэхдээ тэр нь чимж гоёсон үг яриа бус жинхэнэ бодит ажил болох хүрээлэн буй орчин, нийгмийн цогц зорилтуудыг тодорхойлно.

2025 оноос цааш: Их шилжилт: Энэ үед урьд өмнө байгаагүй эрх чөлөө, тэвчээр, ёс журам бий болж тогтвортой хөгжлийн шинэ загвар жинхэнэ утгаараа үйлчилнэ. Экологийн мэдрэмж хүн төрөлхтний гол үнэлэмж болно. Гэхдээ энэ бол диваажин бус. Тэнд бодит хүмүүс амьдарна. Зөрчилдөөн, дургүйцэл, эмгэнэлт явдал арилахгүй. Гэвч өнгөрсөн зуун улам илүү тогтвортой, чөлөөт ертөнцөд хүрэх түүхэн боломжийг бий болгосон байна. Байнгын өөрчлөлтийн гол хүч болох глобал сүлжээний тархалт, Үнэлэмжид үндэслэгдсэн байгууллагуудын холбоо болон өөрсдийнхөө асуудлыг шийдвэрлэх хариуцлагаа ухамсарласан хувь болон бүлэг хүмүүсийн хүсэл зоригийн тусламжтайгаар иргэний нийгэмийн даяаршил явагдана. Тоон аппарат, бусад хүлээн авагчаар тоноглогдсон Үнэлэмжид үндэслэгдсэн байгууллагуудын дэлхийн сүлжээ, интернет нь үндэстэн дамнасан корпорацууд болон чадваргүй засгийн газруудын эсрэг нөлөөлөх гол хэрэгсэл болох бөгөөд түүний тусламжтайгаар хүрээлэн буй орчны байдал, ажлын нөхцлийн чанар, цалинд хяналт тавьж, орчноо хохироож буй компануудад шахалт үзүүлж, хэрэглэгчдээр бүтээгдэхүүнд нь хориг тавиулж болно.

2. Дэлхийн ирээдүйн зах зээлийн хөгжил, бизнесийн шинэ боломжууд

Ирээдүйн хэрэглэгчдийн зах зээл, хөдөлмөр нь шинээр үүсэн түргэн өсч буй зах зээлд төвлөрөх болно. Эдгээр зах зээл нь хүмүүсийн үндсэн хэрэгцээнд үйлчлэх, хүний ур чадварыг сайжруулах, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг арилгах, хүрээлэн буй орчныг хамгаалахад Засгийн газар болон иргэний нийгэмтэй түншилсэн бизнест ивээлээ хүртээх магадлалтай.

Хүн ам - Хөгжиж буй бүс нутагт залуучууд зонхилсон хүн ам өргөжснөөр том зах зээлийг бий болгоно: Өнөөдөр 6.2 тэрбумаар тоологдож буй дэлхийн хүн ам 2025 он гэхэд 8 тэрбумд хүрч өснө гэж тооцоолж байна. Энэхүү өсөлт нь ирээдүйн зах зээлийг тодорхойлохын зэрэгцээ хүрээлэн буй орчин, дэлхийн иргэдийн эрүүл мэнд, хүнс тэжээл, боловсрол, баялагт нөлөөлөх болно. Хүн ам ирэх 20 жилд өндөр орлоготой /нэг хүнд ногдох ҮНБ нь 9266 ам.доллараас дээш/ орнуудад бараг өсөхгүй, харин дэлхийн ихэнх шинэ иргэд бага болон дунд орлоготой /нэг хүнд ногдох ҮНБ нь 755

ам.доллараас бага/ орнуудад төрөх болно. Өөрөөр хэлбэл дэлхийн нийт хүн амын өсөлтийн 98% нь хөгжиж буй орнуудад ногдоно. Иймд хэрэглэгчдийн зах зээлийг ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүмүүсийн үндсэн хэрэгцээ болон өргөжин тэлэх дунд давхаргын хэрэгцээг хангахад чиглүүлэхийг шаардах болно. Хөгжиж буй орнууд өөрийн дотоод үйлдвэрлэлээ хөгжүүлэх замаар хүн амдаа үйлчлэх учраас өнөөгийн үндэстэн дамнасан корпорацууд тэрхүү шинэ зах зээлд үйл ажиллагаагаа явуулахад тохируулан өөрийн стратеги, техник, үйл ажиллагаа, маркетингийн чадавхаа хөгжүүлэх шаардлагатай.

Эд баялаг - Баялагийн үйлдвэрлэл нэмэгдэх боловч баян ядуугийн ялгаа улам ихсэнэ: Бизнесийг урт хугацаанд өсөлттэй байлгах боломжийг хангахын тулд сая сая хүнийг даяаршлын эдийн засагт хамруулан өндөр болон бага орлоготой орнуудын орлогын ялгааг ойртуулах шаардлагатай. Дунд болон бага орлоготой хэрэглэгчдийг өргөжүүлэх нь зах зээлийн боломжийг бүрдүүлэх бөгөөд энэхүү зэх зээлд гарах бараа, үйлчилгээг бий болгох шаардлага нь бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэл, бизнесийн шинэ загвар, бизнесийн өсөлтийн хөдөлгүүр болно.

Хоол тэжээл, эрүүл мэнд - Дэлхий хүнсээр дүүрэн байх боловч сая сая хүмүүс хоол тэжээлийн дутагдалтай хэвээр байна: Хоол тэжээлийн дутагдалтай байгаа орнуудад зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг болох үйлдвэрүүдийг хүнсний нийлүүлэлтийн гинжэн хэлхээнд шууд ба шууд бусаар татан оролцуулах явдал нь дэлхийн эдийн засгийг өсөлтөд хүргэх боломж олгоход чухал хувь нэмэр оруулах болно.

Хүн амын дундаж наслалт нэмэгдэх боловч урьдчилан сэргийлж болох өвчин үргэлжлэн гарсаар байна: Хүний эрүүл мэнд бүтээмжид шууд нөлөөлөх учраас энэ бол бизнесийн хамгийн гол асуудлын нэг болно. Хөгжиж буй орнуудын хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулах нь хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалтыг сайжруулах, эрүүл мэндийн боловсрол, гэр бүлийн төлөвлөлтийн үйлчилгээг нь сайжруулах, дархлаажуулалтад өргөн хамруулах, цэвэр усаар хангах, урьдчилан сэргийлэх эмчилгээ, эрүүл ахуйн эдийн засгийн урамшуулалыг бий болгохыг шаардана. Иймд эмийн үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээ, усны дэд бүтэц, усны ариун цэвэр зэрэг салбарт нийтийн эрүүл мэндийн асуудлыг техникийн хувьд шийдвэрлэсэн хувийн компанууд стратеги боломж олох болно. Харин нийтийн эрүүл мэндийн асуудалд бизнесийн алдаа гаргасан компанууд өөрсдийгөө улс төр, нийгмийн зөрчилтэй асуудалд оруулах болно.

Боловсрол - Анхан шатны боловсрол өргөжих боловч суралцах боломжийг олон хүн ашиглаж чадахгүй: Дэлхийн эдийн засаг улам улмаар оюуны мэдлэг, үйлчилгээнд тулгуурлах болж байгаа болохоор дунд болон техникийн боловсролын сургалтаар оюуны ур чадварыг нэмэгдүүлэх явдал улам чухлаар тавигдах болно. Бизнес нь түүний үйл ажилагаа явуулж буй нийгмийн бүлгүүдийн боловсролын системд шууд хамааралтай. Тухайлбал, орчин үеийн бизнест бүтээлч ажилчид байхын тулд хөдөлмөрийн армид орж буй хүмүүс зохих ур чадвартай байх явдлыг хангах нэмэгдэл хөрөнгө оруулалт, нөөц шаардагдах болно. Энэхүү хөрөнгө оруулалт, нөөцийг дайчлахын тулд улсын болон хувийн салбарын байгууллагуудын хооронд шинэ түншлэлийг бий болгож, хүмүүсийг тухайн зах зээлд үйлчлэх ур чадварыг эзэмшүүлсэн байх шаардлагатай.

Шинэчлэл - байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэл бий болгоно: Дэлхийн хэмжээнд эд баялагийн үйлдвэрлэл нэмэгдсээр байгаа нь амьдрал сайжрах горьдлогыг төрүүлж байгаа боловч хэрэв хэрэглээ, эрчим хүчний үйлдвэрлэл, хог хаягдлын одоогийн хэв маяг хэвээр байх бол сав шимийн тогтолцоонд ихээхэн эрсдэл үзүүлэх болно. Хэрэглээ, хог хаягдлыг багасгах шаардлага нь бизнест өсөлтийн шинэ боломж олгохын зэрэгцээ хог хаягдал гаргадаг процесс, бараа, үйлчилгээг шинэчлэх замаар хүмүүс, эдийн засаг, сав шимийн тогтолцоонд туслах боломж олгоно.

Хэрэглээ - Хэрэглээний өсөлт нь хүрээлэн буй орчинд эрсдэл, бизнест шинэчлэлийн боломж олгоно: Орлогын өсөлт нь хүмүүст мах, сүүн бүтээгдэхүүн, компьютер, эрчим хүч, цааснаас эхлэн хөргөгч, зурагт, авто машин хүртлэх аливаа зүйлийн хэрэглээгээ өргөтгөх боломж олгоно. Хүнс, орон сууц, цэвэр ус, тээврийн илүү хэрэглээ нь олон үндэстнүүдэд ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой. Харин дэлхийн баян хэрэглэгчдийн өндөр хэрэглээ нь сав шим тогтолцоонд сөрөг үр дагаварыг бий болгоно. Түүхий эд, материал, нөөцийн эрчимтэй хэрэглээний өнөөгийн загвар нь сав шим тогтолцооны зохицолдоог эвдэж, манай гаригийн хаягдал шингээх чадавхаас давах эрсдлийг бий болгож байна. Бүх хүмүүсийн хэрэгцээ, хүслийг хангахын зэрэгцээ нөөцийг хадгалан үлдээхийн тулд технологи, бизнесийн загварыг шинэчлэх шаардлагатай.

Эрчим хүч - Эрчим хүчний хэрэглээ өсөх нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах боловч дэлхийн уур амьсгалд аюул учруулж болзошгүй: Дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэл 1980-аас 2000 оны хооронд 43% өссөн бөгөөд 2050 он гэхэд 150-230% өсөх болно. Эрчим хүчний салбарын гол шаардлага бол байгаль орчинд

сөрөг нөлөө багатай, үр ашиг бүхий эрчим хүчээр хангах явдал болно. Өнөөгийн байдлаар 2 тэрбум хүн эрчим хүч хэрэглэж чадахгүй байгаа бөгөөд энэ нь нарны зайн генератор, бага оврын салхин турбин, шингэн түлшний зай, биомассын генератор гэх мэт цахилгаан дамжуулах шугам, хоолой, цахилгаан станц зэрэг дэд бүтэц шаардахгүйгээр хөдөөгийн эрчим хүчний хэрэгцээг хангаж чадах бие даасан эрчим хүчний системийн асар их зах зээл байгааг харуулж байна. Эрчим хүчээр цангасан аж үйлдвэрийн эдийн засгийг хангах зах зээлийн боломж нь эрчим хүчний цэвэр эх үүсвэр буюу нар, салхи, байгалийн хийн эрчим хүчийг түргэн хөгжүүлэхэд оршиж байна. Харин хатуу түлшний үнэ цаашид нэмэгдэх магадлалтай.

Хийн ялгаруулалт - Агаарын бохирдол дэлхийн хэмжээний асуудал хэвээр байна: Хатуу түлшний ашиглалтаас гарах хийн ялгаруулалтаас шалтгаалах агаарын бохирдол, химийн хордуулалт, үйлдвэрлэлээс гарах хаягдлын хэмжээ дэлхийн ихэнх хэсэгт нэмэгдэх хандлагатай бөгөөд тэр нь дэлхийн шингээх чадавхаас давж, уур амьсгалын өөрчлөлт, хүчлийн бороо, байгалийн төрөл зүйлийн мөхөлд нөлөөлнө. Өнөөгийн эдийн засгийн үйл ажиллагаа нь материал, эрчим хүчийг байгалаас булаан авч түүнийг амьдралын богино хугацааны хэрэглээ болгосны дараа дэлхийн хий мандал, газар, усанд хаягдал болгодог шугаман системийн үүрэг гүйцэтгэж байна гэж хэлж болно.

Хаягдал болон хийн ялгаруулалт нь алдагдаж буй үнэт зүйл, бизнесийн үр ашиггүй зардал болохын зэрэгцээ өнөөгийн болон хойч үе, сав шим тогтолцооны эрүүл мэндэд аюул учруулж байна. Хаягдлаас урьдчилан сэргийлэх, сэргээгдэх нөөцийг ашиглах, хаягдлыг цуглуулан бусад процессийн орц болгох аж үйлдвэрийн загвар боловсруулах замаар зардлаа бууруулан ашгаа нэмэгдүүлэх асар их боломж бизнесүүдэд байна.

Үр ашиг - Эрчим хүч, материалын үр ашиг сайжирч, материалын гарц нэмэгдэнэ: Компаний болон үндэстний эдийн засгийн түвшин нь нөөцийн ашиглалт, хаягдлын боловсруулалаас шууд хамаарна. Үр ашгаа нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн процессийг сайруулж, хаягдал бүтээгдэхүүнийг эргэлтэнд оруулж, материал бага шаардах бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай. Үр ашиг сайжирснаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах боломж олгоно. Үйлдвэрлэл, хэрэглээг зохицуулах замаар үр ашгаа нэмэгдүүлэх оролдлого хийж, үр ашигтай бүтээгдэхүүний хэрэгцээ бүхий зах зээлд үйлчилж чадсан компанууд өрсөлдөх давуу талтай болж, шинэ зах зээлд үйл ажиллагаагаа явуулах боломжтой болж чадна.

Байгалийн капитал – байгалийн нөөцийн баазыг хадгалахад анхаарна: Дэлхийн эдийн засаг нь өнөөдөр ноцтой элэгдэлд орох хандлагатай байгаа байгалийн нөөцийн бааз болох «байгалийн капитал»-аас хамаарна. Хүрээлэн буй орчны хадгалалтыг сайжруулахгүйгээр ирээдүйн биенесийн үйл ажиллагаа нь ус, материалын болон хаягдал зайлуулах үнийн өсөлтийн эрсдэлд орох аюултай. Өөрийн үйл ажиллагааныхаа хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгасан компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ л гацхүү өрсөлдөх давуу талыг олно. Одоогийн байгаа болон шинээр бий болох зах зээлд удаан хугацаагаар үйл ажиллагаагаа явуулж чадах эсэх нь амьтан, ургамалын амьдрах орчин, байгалийн нөөцийг сэргээх бизнесийн стратегиас шууд хамаарах болно.

Сав шим тогтолцоо - Гариг ертөнцийн бүтээх чадавхи буурна: Байгалийн төрөл зүйлс хоорондоо харилцан нөлөөлж бодитойгоор амьдрах сав шим тогтолцоо нь бидний амьдралыг бий болгон тэтгэх байгалийн үнэт зүйл /капитал/ мөн. Бэлчээр, ой, далайн эрэг орчмын газар, гол мөрөн зэрэг сав шим тогтолцоонууд нь хоол хүнс, ус, агаар, биологийн төрөл зүйл, цаг уурын тогтвортой байдлыг бий болгож, хүмүүст гоо сайхны таалал, амралт болохын зэрэгцээ бидний хаягдлыг боловсруулж байдаг. Тэрхүү сав шим тогтолцоонууд нь ажлын байр, орлогыг ч бий болгодог.

Хувийн хэвшлийнхэн байгалийн баялагийг ухаалгаар ашиглах сонирхолтой төдийгүй эдийн засгийн боломж ч тэдэнд байгаа юм. Сав шим тогтолцооноос бидэнд өгч буй олон бүтээгдэхүүн, үйлчилгээг боломжийн зардлаар орлуулах боломж байхгүй. Сав шим тогтолцооны бараа, үйлчилгээг нийтийн «чөлөөт» бараа мэт бус, харин түүнийг хадгалах урамшил бий болгох зорилгоор зах зээлийн үнэт зүйл болгох сонирхол улам нэмэгдсээр байна.

Хөдөө аж ахуй - Хүнсний үйлдвэрлэл олон орны эдийн засгийн бааз хэвээр байх боловч түүнээс шууд хамаарал бүхий сав шим тогтолцоонд аюул учруулна: Бид хүнсээ хэрхэн үйлдвэрлэх сонголтоос ирээдүйн бэлчээр, ой, далайн болон бусад сав шим тогтолцоо хамаарах болно. Хүн амын өсөлтийг хадгалан ирэх арван жилд хоол тэжээлийн дутагдлыг багасгах явдал нь хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө багатай хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийг шаардана. Үр тариа, амьтны гаралтай уургийн хэрэгцээг хангах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь ой, бэлчээрийг сүйтгэж байна. Тийм учраас сав шим тогтолцооны хувьд үр ашиг бүхий хүнсний үйлдвэрлэл эрхлэх явдал эдийн засаг, хүн төрөлхтний хөгжлийн тэргүүн зорилтуудын нэг болно.

Цэвэр ус - Хүмүүсийн хэрэглээний өрсөлдөөн дунд цэвэр усны нөөц улам ховордоно: Цэвэр устай байх эсэх нь дэлхийн нөөцийн хамгийн чухал бөгөөд хүнд асуудал болно. Ус бол бүхий л амьдралын эх сурвалж, ялангуяа хөргөх, хүнс боловсруулах, химийн үйлдвэрлэл явуулах, усжуулалт зэрэг бизнесийн үйл ажиллагааны үндэс болдог.

Усны нөөцийн улам нэмэгдэж буй хомсдол, усанд байгаа биологийн төрөл зүйлийн ховордол нь дэлхийн ихэнх хэсэгт амьдралын чухал эх сурвалж болох усны нөөцийг хамгаалах бодлого, бодит үйл ажиллагаа алдаатай байсныг нотлон харуулж байна. Хүн амын өсөлт, үйлдвэржилт, хотжилт, хөдөө аж ахуйн эрчимжилт, усыг хайр гамгүй хэрэглэх амьдралын хэв маяг зэрэг нь цэвэр усны системд хэт их дарамт болж байгаагийн зэрэгцээ усны ашиглалт, бохирдуулалт нь ашиглаж болох усыг улам хомс болгож байна. Хөдөө аж ахуйн эрчимжилт, хотжилтын түргэн өсөлтөөс шалтгаалан ихэнх бүс нутгуудад усны чанар муудаж байгааг хүлээн зөвшөөрч байгаа юм. Дэлхийн нийт цэвэр усны хэрэглээний 70% нь хөдөө аж ахуйд ногдож байна. Химийн бордоо, пестицид, малын өтөг зэргийг газар тариаланд хэт хэрэглэснээс азот, фосфор, хүнд металаар ус бохирдож, усны чанарын ноцтой асуудлыг бий болгож байна. Цэвэр усны дээрхи асуудлууд усны үнийг нэмэгдүүлэх учраас усны ашиглалтын үр ашгийг сайжруулах шаардлага тулгамдсан зорилт болно.

Уялдаа, холбоо - Сүлжээгээр хэрэгдсэн ертөнц дахь бизнес: Хүмүүсийн нягтрал, технологийн сүлжээ өсч, түргэн өөрчлөгдөж буй ертөнцөд бид амьдарч байна. Мэдээлэл, тээврийн сүлжээнд улам илүү оролцох боломж бүхий хотуудад хүмүүс төвлөрч байна. Мэдээлэл, мэдлэг гэрлийн хурдаар тархаж, хүмүүс, барааны дэлхийг тойрсон хөдөлгөөн урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр нэмэгдэнэ. Энэхүү харилцан холбогдсон ертөнцийн эдийн засгийн хөгжил, хүн бүрийн оролцож болох үр ашиг бүхий хөдөлгөөнийг бий болгох, боловсорсон ажилчид, хэрэглэгчдийг өргөжүүлэхэд бизнесийн үйл ажиллагаа онцгой үүрэгтэй.

Хотжилт - Хотжилтын өсөлт нь бизнесийн боломж, нийгмийн асуудлуудыг төвлөрүүлнэ: Хотуудын хүн амын өсөлт, хөдөөгөөс хот руу шилжих хүмүүсийн хөдөлгөөн, хөдөөгийн сав шим тогтолцооны доройтол, ажиллах хүчний хөдөө аж ахуйгаас аж үйлдвэрт шилжилт, хөдөөгөөс илүү хот газарт оруулах улсын хөрөнгө оруулалт, улс төрийн өөрчлөлт зэргээс шалтгаалан хотжилтын үйл явц дэлхий нийтээр явагдаж байна. 2010 оны түвшинд дэлхийн бүх хүн амын 50% нь хотод амьдрах бөгөөд хөгжиж буй орнуудад 1950

онд хүн амын 20% нь хотод байсан бол 2010 онд 40-өөс дээш хувь нь хотод амьдрах болно. Өнөөгийн байдлаар жилд 60 сая шинэ иргэнээр нэмэгдэж байгаа нь сар тутам өөр Парис, Бээжин буюу Кайроогоор нэмэгдсэнтэй тэнцэж байна. Хотжилттой холбогдон эрчим хүч, дэд бүтцийн хэрэгцээ их болохоос гадна хөдөлмөр, хэрэглэгчид төвлөрөх учраас тэр нь бизнест хамгийн ашигтай байх болно. Хотжилт ялангуяа хөгжиж буй орнуудад эрчимтэй явагдаж, тэр нь шинэ боломжийг бизнест олгохын зэрэгцээ хэрэглэгчдийн хэрэгцээнд үйлчлэх зардлыг бууруулна. Эдгээр боломжуудыг ашиглахын тулд бизнесийнхэнд өөрсдөө үйл ажиллагаа явуулж, амьдрах хотоо улам сайхан болгох бизнесийн стратеги, улс-хувийн түншлэл зайлшгүй шаардлагатай.

Хөдөлгөөнт байдал - Хүн төрөлхтөн улам хөдөлгөөнтэй болж, бараа, мэдлэгийн урсгалыг хурдасган, эрчим хүч, дэд бүтцийн хэрэгцээг нэмэгдүүлнэ: Зам, авто машин, нийтийн тээвэр, агаарын тээвэрт илүү оролцох замаар хүн төрөлхтөн улам илүү хөдөлгөөнтэй болно. Хүмүүс, барааны хөдөлгөөн нь эдийн засгийн болон бизнесийн хөгжилд чухал. Хөдөлгөөнт байдал нь хөдөлмөрийг хувиарилах, хотыг өсгөх, түүхий эд, материалыг худалдах, ачааг хурдан бөгөөд хямд тээвэрлэх, ажилчдыг хурдан шилжүүлэх боломж олгоно. Хүмүүсийн глобал урсгал нь ажлын болон зах зээлийн байршлаараа ялгагдах бөгөөд мэдлэг, мэдээллийн солилцооны албан болон албан бус сувгийг бий болгоно. Энэхүү хөдөлгөөнт байдал нь эрчим хүч, дэд бүтцийн хэрэгцээг улам ихэсгэнэ. Бага бохирдуулдаг, илүү үр ашиг бүхий хөдөлгөөнд оролцох явдал нь бизнесийн хувьд шаардлага төдийгүй боломж болно. Ачаа тээвэрлэлт нь бизнес болон хувь хүмүүст ашигаа өгч амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа боловч хүрээлэн буй орчны болон нийгмийн асуудлуудыг дагуулж байгаа юм. Авто зам, агаарын тээвэр огцом ихсэж, харин нийтийн тээвэр багасах хандлагатай байна.

Өсөн нэмэгдэж буй хөдөлгөөнт байдал нь олон улсын бизнесийн 24 цагийн ажлын өдрийг бий болгож, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийг хурдасгана.

Мэдээлэл, холбоо - Мэдээлэл холбооны технологи- эдийн засгийн боломжийг нэмэгдүүлнэ: Дэлхийн олон хэсэгт телефон, интернетийн ашиглалт хязгаарлагдмал байгаа боловч тэр нь түргэн тархаж байна. Интернетийн ашиглалт нэмэгдэх тутам тэр нь зах зээл, нийгмийн бүлгүүдийг хооронд нь зангидаж, дэлхийн хэмжээнд мэдлэг, үйлчилгээ солилцох, хүмүүс, барааг хөдөлгөх боломж олгож байна. Мэдээлэл, холбооны технологийг ашиглах нь хувийн хэвшилд

шинэ үйлдвэрлэл эзэмших, бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, нийлүүлэлтийн бүх гинжин хэлхээний үр ашгийн сайжруулахад нь туслана. Тоон сүлжээ нь бүтээмжийг сайжруулахын зэрэгцээ хүмүүст байгалийн нөөц ашиглалтаас эхлэн улс төр хүртэлх хүрээнд тэдний амьдралд нөлөөлөх шийдвэр гаргахад оролцох боломж олгоно.

Хөдөлмөр эрхлэлт - Эдийн засаг үйлчилгээнд суурилах болохоор эмэгтэйчүүд албан ёсны ажиллах хүчний өсөн нэмэгдэх хэсэг нь болно: Дэлхийн хэмжээнд ажиллах хүч өсөхийн зэрэгцээ хөгжиж буй орнуудын эдийн засаг хөдөө аж ахуйгаас аж үйлдвэр, үйлчилгээнд суурилах болохоор эмэгтэйчүүд албан бусаас албан ёсны хөдөлмөрийн салбарт шилжих болно. 2025 он гэхэд хөдөлмөрийн хүчний өсөлт бараг бүхэлдээ бага болон дунд орлоготой орнуудаас гарах бөгөөд шинэ ажилчдын ихэнх нь аж үйлдвэржилт, технологи, мэдээлэлд суурилагдсан аж үйлдвэрийн шаардлагад нийцсэн мэргэшил, ур чадварыг эзэмших шаардлагатай болно. Дэлхийн хэмжээний өрсөлдөөн нь улам илүү нээлттэй худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хувьчлалын өргөн боломж олгож, экспортод чиглэсэн үйл ажиллагаа дэлхийн хэмжээний ирээдүйн дүр төрхийг илэрхийлэх болно. Зарим газарт ажиллах хүчнээ алдаж, нөгөөд нь өсөлт гарах магадлалтай. Эдгээр өөрчлөлтүүд нь эмэгтэйчүүдэд илүү боломж бий болгоно. Хөгжилтэй орнуудад хөдөлмөрийн /16-60/ насны хүн ам 2000-2025 онд 740 саяаас 690 сая болж буурна. Харин хөгжиж буй орнуудад хөдөлмөрийн насны хүн ам 43% буюу ойролцоогоор 3-4 тэрбум болж өснө. Ойролцоогоор эмэгтэйчүүдийн 50% нь албан ёсны хөдөлмөр эрхэлж, нийт ажиллах хүчний гуравны нэг болно. Гэвч эмэгтэйчүүд харьцангуй ижил ажлын байранд эрэгтэйчүүдийн авах цалингийн гуравны хоёрыг авах бөгөөд нийт цалингийн сангийн тавны нэгээс бага хэсэг нь эмэгтэйчүүдэд очно.

Эдийн засаг хөгжихийн хэрээр хөдөө аж ахуйд ажиллах хүмүүсийн тоо багасч, аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллах өндөр мэргэжлийн хүмүүс илүү шаардагдах болж, дэлхийн эдийн засгийн баялаг хүмүүсийн ажиллаж буй салбарын харьцаагаар хуваарилагдах болно.

Үүрэг, хариуцлагын ухамсарлалт - Үйл ажиллагаагаа явуулах зөвшөөрөл шаардагдах болно: Бизнес нь үйл ажиллагаагаа үндэсний хууль, дүрэм, журам, стандартууд болон олон улсын гэрээ, хэлэлцээр, гадаад, дотоодын иргэний нийгмийн стандартад нийцүүлэх шаардлагатай. Олон нийт болон засгийн газар нь бизнесүүдээс нийгмийн талаар хариуцлага хүлээж, хүний үндсэн

хэрэгцээг хангах, хөгжил, ардчилалыг дэмжих, мэдээллээ хуваалцаж, түүнийг иргэний нийгэмд нээлттэй байлгахыг шаардах болно.

Ардчилал - Ардчилал улам өргөжин зах зээлд суурилагдсан эдийн засгийн нөхцлийг сайжруулна: Түүхэнд урьд өмнө хэзээ ч байгаагүй олон хүн сонгуульт, ардчилсан засгийн газартай орнуудад амьдрах болно. Олон орнууд төрийн хяналт бүхий эдийн засгаас зах зээлд суурилагдсан аргад шилжсэн явдал нь олон улсын бизнесийн өрсөлдөөний тогтвортой үйл ажиллагааны нөхцөл, зохицуулалтын журмуудын нэгдмэл багцыг бий болгоход хувь нэмрээ оруулсан юм. Улс орнууд хүний эрхийн болон хүрээлэн буй орчныг хамгаалах стандартууд зэрэг олон улсын засаглалын хэрэгсэлийг нэвтрүүлж, Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ын гишүүний хувьд тодорхой ашиг олж байна. Мэдээллээр цэнэглэгдсэн олон нийт, төрийн бус байгууллагууд, чөлөөт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл зэрэг авилгалын эсрэг тэмжэж болох бүх нөхцөл байдал ардчилалд их тус нэмэртэй.

Хариуцлага - Засгийн газар, бизнесээс иргэний нийгэм улам илүү хариуцлага, ил тод байдлыг шаардах болно: Засгийн газар, бизнест иргэний нийгэмлэгээс үзүүлэх нөлөөлөл улам ихэссээр байна. Бизнес, Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд улам ил тод байлгах, харилцагчид, хувьцаа эзэмшигчид төдийгүй хууль, олон талын оролцогчдын өмнө улам илүү хариуцлага хүлээлгэх талаар төрийн бус /ТББ/ олон байгууллагууд ажиллах болно. Бизнесүүдээс олон нийтийн энэхүү ашиг сонирхлын хариуд хүрээлэн буй орчин, нийгмийн талаархи үйл ажиллагаа, нөөцийн ашиглалт, эрчим хүч, хүрээлэн буй орчны талаар олон нийтийн зүгээс тавьж буй шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шинэчилсэн талаархи тайлангаа гаргаж мэдээлдэг болно. Тэр нь зах зээлд бизнесийн үйл ажиллагаа явуулах лиценз болсноор бизнесийн нэр хүндийг өргөх хэрэгсэл болно. Интернетийн ашиглалт нь хөрөнгийн зах зээлд оролцох олон нийтийг өргөжүүлж, нийгмийн өмнө хүлээх нэгдсэн хариуцлагыг өргөн утгаар тодорхойлох боломж олгож, тэгснээр хувьцаа эзэмшигчдийн идэвх нэмэгдэж, корпорацуудад хөрөнгө оруулалтын шинэ стратеги бий болгох шахалт үзүүлэх болно.

Ашигласан материал

1. Global Future Group, Environmental Institute, "Great Transition", Stockholm, 2002
2. Tomorrows Market. www.workathomebiz.info/-23k-13cap2005
3. Business Opportunity Reports. www.bccresearch.com/archive/commind
4. Assessing Future Market Opportunity www.researchandmarkets.com/reportinfo